



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

**Тогтоолд нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Хууль зүйн байнгын хорооны 2015 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 17 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасан Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга Ө.Энхтөр, Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Л.Мөнхцэцэг, мэргэжилтэн Б.Гантуяа, Хууль сахиулахын их сургуулийн Удирдлагын сургуулийн захирал Ж.Ганбаатар, Хууль сахиулахын их сургуулийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч Г.Оюунболд нарыг нэмсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Д.ГАНБАТ